

Хэн хамгийн агуу нь вэ?

Энэ гарын авлагыг бүлгээрээ хийж гүйцэтгээд, асуултуудад хэрхэн хариулах талаар ярилц.

Хийх дуртай зарим үйл ажиллагаагаа жагсаан бич. _____

- Та нарын жагсаан бичсэн үйл ажиллагааг үнэхээр сайн гүйцэтгэдэг зарим хүнийг нэрлэ. Тэднийг чухам юу агуу болгодог вэ?

Та нар Марк 10 дээрх Аврагчийн үгсийг судалж байхдаа Тэрээр хүнийг юу үнэхээр агуу нэгэн болгодог хэмээн заасныг олж мэд.

Марк 10:35–37-г уншаад, Иаков, Иохан нар Иерусалим руу аялж байхдаа Аврагчаас юу хүссэнийг олж мэд.

Иаков, Иохан нар Есүсийн баруун, зүүн талд суухыг гуйсан нь тэд Бурханы хаант улсад бусад төлөөлөгчийн хүлээн авахаас илүү дээд алдар суу, хүндэтгэлийг авахыг хүссэн гэдгийг харуулдаг. Марк 10:38–40-д Аврагч энэ адислал нь хүлээн авахад бэлтгэгдсэн хүмүүст өгөгдөх болно гэж Иаков, Иохан хоёрт тайлбарласан тухай цэдэглэсэн байдаг.

Марк 10:41-ийг уншаад, бусад шавь нь Иаков, Иохан хоёрын гуйлтад хэрхэн хандсаныг олж мэд.

- Бусад шавь нь яагаад Иаков, Иохан хоёрт дургүйцсэн гэж та нар бодож байна вэ?

Марк 10:42–45-ыг уншаад, Аврагч шавь нартаа агуу байдлын талаар юу гэж заасныг олж мэд.

Аврагчийн агуу байдлын талаар заасан зүйлс дээр үндэслээд дараах өгүүлбэрийг гүйцээж бич:

Бид үнэхээр агуу байхын тулд, . . . _____ ёстой.

45-р шүлэгт буй *үйлчлэх* гэдэг үг нь бусдыг халамжилж, тайтгаруулах, бусдад тусалж, тэднийг дэмжих гэсэн утгатай.

- Яагаад (Аврагчтай адил) бусдад үйлчилж, тохинуулдаг хүмүүсийг агуу гэж үздэг вэ?
- Хэзээ хэн нэгэн та нарт эсвэл танай гэр бүлд үйлчилж, та нарыг халамжилж байсан бэ? Та нар тэр хүнийг яагаад агуу хүн гэж үзэж болох вэ?

